

**ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН  
ТАСГИЙН 2022 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.12.15 өдөр

Сайнцагаан сум

2022 онд Дундговь аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн ХШДА-н тасаг нь Нийгмийн даатгалын хэлтсийн даргын НДЕГ-н даргатай байгуулласан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 арга хэмжээ, Дундговь аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 арга хэмжээг хэрэгжүүлэн, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтонд хяналт тавьж ажиллаж байна.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАЛААР**

**Шалгалтаар:**

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- (<http://10.9.0.5/monitoring>)-д тулгуурлан 2022 оны 12 төрлийн 1422 мэдээлэл зөрчилтэй байгаагаас 1393 мэдээллийг шалгаж зөрчлийг арилгасан. Шалгалтын явц 98.1%-тай байна

**Үүнд:**

1. Цалин өөрчилсөн мэдээлэл /даатгуулагчаар/-93
2. Цалин өөрчилсөн мэдээлэл / АО-оор/-205
3. Регистрийн дугаар нэгтгэсэн-7
4. Цалин устгасан мэдээлэл-301
5. Жирэмсэн амаржсаны тэтгэмж эрхийн нөхцөл хянах-8
6. Жирэмсэн амаржсаны тэтгэмж цалинг хянах жагсаалт-195
7. Ажилгүйдлийн тэтгэмжийн эрхийн нөхцөл хянах-1
8. Ажилгүйдлийн тэтгэмжийн цалин хянах-128
9. НДШ төлсөн тэгэвэр авагч-105
10. Даатгуулагчийн төрөл буруу-47

11. 01 код давхардсан даатгуулагч-332

Нийт 1422 мэдээлэл зөрчилтэй байснаас 1393 зөрчлийг хянан шалган шийдвэрлэж биелэлт 98,1%-тай байна.

### **Тэтгэвэр тогтоолт, олголт:**

2022 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст 8204 тэтгэвэр авагчид тэтгэвэр авч байна. Тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж байна. 2022 онд жилийн эцсийн байдлаар нийт-562 тэтгэвэр тогтоогдсон Үүнд: ӨН-440, ТД-104, ТА-18 байна.

Тэтгэвэр олголтыг сар бүр хянаж нэр бүхий 12 иргэнд илүү олгосон 5,7 сая төгрөгийн зөрчил илрүүлж төлбөрийг 100% барагдуулан ажилласан байна.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухайтай холбогдуулан Дундговь аймгийн хэмжээнд тэтгэвэр авагч байгаад нас барсан 169 иргэн өвийн гэрчилгээ гаргуулж мөнгө олгогдохоос өвлөх эрхийн гэрчилгээ гаргуулсан 154 иргэнийн материалыг шалган хүлээн авч холбогдох газар луу явуулж шалгуулан үнэт цаасжуулан мөнгийг олгосон байна. 15 иргэн одоогоор өвлөх эрхийн гэрчилгээ гаргуулаагүй хүлээгдэж байна. Олголт 91,1%-тай байна.

### **Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар**

Зөрчлийн тухай хуулийн сургалтыг Дундговь аймгийн Прокурорын газартай хамтарч Хэлтсийн бүх улсын байцаагч нарт зохион байгуулж цаашид хэрэгжүүлж ажиллахад заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн тухай санал гомдол, өргөдлийг бүртгэж Прокурорын газарт сар бүрийн 28-нд мэдээ хүргэж ажиллаж байна. Тус хэлтэст 2022 онд зөрчлийн шинжтэй 4 гомдол мэдээлэл ирснээс 2 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 2 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа явуулж зөрчлийг шийдвэрлэлээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар дотоодын хяналт шалгалтаар нэр бүхий 8 сумын Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголт, Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг цахим болон цаасан хэлбэрээр шалгаж 28,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж гарсан төлбөрийг 100% барагдуулж ажилласан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар ААН, Байгууллагуудад хяналт шалгалтыг явуулж нэр бүхий 11 ААН, байгууллагад 6,2 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1200000 мянган төгрөгийн торгууль оногдуулж, нөхөн төлбөрийг бүрэн барагдуулан ажилласан байна.

### **Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын талаар**

Монгол Улсын засгийн газрын Эмнэлэг хөдөлмөрийн магадлах дүрэм шинэчлэн баталсан 67 тогтоол, “Эмнэлгийн хуудас олгох, хянах тухай” НДЕГ-н даргын 2021 оны А/38 тоот тушаал, “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ” –ийн тухай ЭМС, ХНХС-ийн А/758 А197 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэх талаар Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвийн эмч нарт 2 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор нийт 75 эмч хамрагдсан.

Эмнэлгийн хуудас цахимаар олгож эхэлсэнтэй холбогдуулан аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нарт цахим эмнэлгийн хуудас бичих, даатгуулагч хүсэлт хэрхэн илгээх талаар сургалтыг 510 аж ахуйн нэгж байгууллагын дарга нягтлан бодогч нарт зохион байгуулсан.

ЭХМК-ийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 02 дугаар сард зохих журмын дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтын тайлан мэдээг хугацаанд нь ЭХМТК-д хүргүүлэн ажиллалаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 2022 оны 04 сарын 12 ны өдрийн А/66 тушаалаар шинэчлэгдэн батлагдаж ЭХМК-н дарга эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах талаар ЭХМК болон ЭХК-ийн дарга гишүүдэд зөвлөмж хүргүүлснээр ЭХМК-ийн гишүүдийн хуралд оролцох оролцоо, үүрэг хариуцлагыг жигдрүүлэн ажиллаж шийдвэр гаргалтанд гишүүн бүрийг оролцуулан олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Хурлын явцад гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийг хуваарилж хуралд оролцох оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэн ажилласнаар хурлын чанар дотоод үйл ажиллагаа жигд сайжирсан. Авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамаарал бүхий этгээдийн мэдэгдэх хуудас”-ыг ЭХМК-ийн гишүүдээр бөглүүлэн үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн хэвшсэн.

Нарийн мэргэжлийн эмч нар болон өрх, сумын эмч нар ХЧА-тай иргэн даатгуулагчид тохирсон эрүүлжүүлэх төлөвлөгөөг гаргаж тухайн төлөвлөгөөний дагуу хийгдсэн эмчилгээ үйлчилгээний дагуу ЭХК болон ЭХМК үр дүнгийг тооцож

ажилснаар эрүүлжүүлэх арга хэмжээ чанаржиж байна. Эмчлэн эрүүлжүүлсэн 45 иргэн даатгуулагч байна.

“Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ” ЭМС, ХНХС-ийн А/758 А197 дугаар тушаалаар шинэчлэгдэн 2022 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. НДЕГ, ЭХМТК-оос зохион байгуулсан Шинэчлэгдсэн журмыг хэрэгжүүлэх чадавхижуулах сургалтанд ЭХМК болон ЭХК-ийн эмч нарыг бүрэн хамруулсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар 129 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг цуцалж, 149 иргэн шинээр тогтоогдсон байна.

Сум өрхийн эрүүл мэндийн төв болон нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн хуудасны үнэт цаасны бүртгэл, зарцуулалтанд хяналт хийн зөвлөмж өгч ажиллалаа.

2022 оны жилийн эцсийн байдлаар 1897 цаасан болон цахим эмнэлгийн хуудсанд хяналт хийсэн.

Цахимаар эмнэлгийн хуудас илгээгдсэн сайн дурын даатгуулагчид хүсэлт хэрхэн илгээх зөвөлгөө мэдээллийг цахимаар болон утсаар зөвөлгөө өгч ажиллаж байна.

2022 оны байдлаар тус ЭХМК-т иргэн (даатгуулагч)-аас нэг өргөдөл гомдол ирснийг шийдвэрлэсэн болно.

### **Бусад ажлын талаар**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дуаар зүйлийн 7.1.1 Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг тус тус үндэслэн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дотоод аудитыг зохион байгуулж хэрэгжүүлсэн. Шалгалтанд Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар тус хэлтэс нь Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Сангийн нийт-161 мэдээлэл байршуулхаас 157 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж 4 мэдээлэл байршуулаагүй байна. Байршуулаагүй 4 мэдээлэл нь тус оны жилийн эцэст байршуулах мэлээлэл байна.

Үйл ажиллагааны нийт-149 мэдээлэл байршуулхаас 115 мэдээллийг цаг хугацаанд байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн, 31 мэдээлэл байршуулаагүй байсанд хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

### **ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ**

